

ТАЙЛАНД

УЛСААС МЭНДЧИЛЖ БАЙНА!

Дэлхий даяарх Тэнгэрлэг
Эцэгийн хүүхдүүдийн
талаар олж мэд.



СОНГКРАН НААДАМ

Тайланд нь Зүүн Өмнөд
Азид оршдог улс юм.
Энд 72 сая орчим
хүн амьдардаг.

Тайландад хүмүүс шинэ жилээ
дэлхийн хамгийн том усан
тулаанаар тэмдэглэдэг. Тэд бие
бие рүүгээ ус цацаж, муу муухай
зүйлээ угаахыг сануулдаг. Энэ
баяр гурав хоног үргэлжилдэг.



ЗАВЬТАЙ ЗАХ

Тайландад хүмүүс жижиг хөвөгч
дэлгүүрүүд шиг голын завинууд дээр
худалдаа хийх боломжтой. Голыг
ашиглан нийслэл хотыг тойрон аялах
боломжтой. Олон барилга байгууламж
усан дээр тогтоох зориулалттай
модон шонгууд дээр байрладаг.



Барын агуй хийд нь олон
хүний шүтэн биширч,
залбирдаг Буддын хийд
юм. Тэнд очихын тулд та
уул өөд 1260 гишгүүртэй
шатаар авирах ёстой.
Уг агуйд барын
сарвууны мөрүүд бий.

БАРЫН АГУЙ



MONGOLIAN

Тай нь энэ улсын албан
ёсны хэл юм. Тай цагаан
толгой нь 72 үсэгтэй.

Тай хэлээр чи
найзтайгаа "кин
као ру ян" гэж
мэндчилж болно.

Энэ нь "Та
идэж амжсан
уу?" гэсэн
утгатай.

Энэхүү жорыг хуваалцсан Панягийн гэр бүлд баярлалаа!



ҮЙЛ
АЖИЛЛАГАА

Могой сүүлээ хаздаг

Нэг хүнийг 1-р могой, өөр нэг хүнийг 2-р могой болго. Бусад нь бүгдээрээ 1-р могойны ард зогсоод, өмнө нь зогсож буй хүнээс барина. 2-р могой 1-р могойны хажуугаар өнгөрөхдөө эгнээний хамгийн сүүлийн хүнийг барих гэж оролдоно. Баригдсан хүн бүр тоглоомоос хасагдана.



ЖОР

Сом Там

Ногоон папаяа жимсний салат бол Тайландад түгээмэл жор юм. Та энэ хувилбарыг туршиж үзээрэй.

1. Том аяганд **1 ½ цайны халбага далдуу модны сахар** (эсвэл бор сахар), **1 ½ цайны халбага загасны соус** (эсвэл шар буурцгийн соус), мөн **2 цайны халбага нимбэгний шүүстэй** холино. Сахарыг нь уустал хутгана.
2. **2 хумс саримс** болон **1 юм уу хэдэн ширхэг халуун улаан чинжүү** хэрчинэ. **3 ширхэг ногоон шошоо** жижиглэнэ. **1 ширхэг улаан лоолио** хошуулдан зүснэ.
3. **1 ширхэг ногоон папаяа** (эсвэл **3 ширхэг ногоон алим**) хальслаад үрүүлээр үрж эсвэл нарийхан хэрчинэ.
4. Бүгдийг нь аягандаа хийгээд, хутгана.